



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2015 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 31


Мандалговь

Хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Төв халхын дуулалт жүжгийн театрт хавсралтын дагуу өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн 3,000,000 /гурван сая/ төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэж авахыг зөвшөөрсүгэй.
2. Шинээр бэлтгэсэн эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын данс бүртгэлд бүртгэж авахыг Төв халхын дуулалт жүжгийн театрын дарга Д.Доржсүрэнд даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА



С.БУДЖАВ

Аймгийн ИТХТ-ийн 2015 оны 08 сарын  
28 өдрийн 31-р тогтоолын хавсралт



Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

| Д/д      | Нэр төрөл         | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэгжийн үнэ | Нийт үнэ  |
|----------|-------------------|-------------|------------|-------------|-----------|
| 1        | LED урсдаг самбар | ш           | 1          | 1,500,000   | 1,500,000 |
| 2        | Тольтой шүүгээ    | ш           | 8          | 100,000     | 800,000   |
| 3        | Хувцасны өлгүүр   | ш           | 2          | 350,000     | 700,000   |
| Нийт дүн |                   |             |            |             |           |